

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Эрдэнэт сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код : ОРА-2022 /8/НА-СТА-ОНТС

Цахим хуудас:

www.audit.mn

Эрдэнэт хот

2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Т.Болормаа
Утас: 70350757 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
4.1 Залруулсан алдаа	12
4.2 Албан шаардлага	12
4.3 Зөвлөмж	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан
ТУХ	Төслийн удирдах хороо



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 89
танай _____-ны № _____-г

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
Н.БЯМБАЦЭЦЭГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Эрдэнэт сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Эрдэнэт сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,212,232,649	3,690,946,367
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,981,921,102	3,537,729,464
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	10,981,921,102	3,537,729,464
3121	Төгрөг	10,981,921,102	3,537,729,464
31211	Төрийн сангийн харилцах	10,981,921,102	3,537,729,464
33	АВЛАГА	230,311,547	153,216,903
335	Бусад авлага	2,716,000	2,716,000
3351	Байгууллагаас авах авлага	2,716,000	2,716,000
336	Зээлийн авлага	227,595,547	150,500,903
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	227,595,547	150,500,903
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	184,125,214	150,500,903
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,895,000	2,024,000
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,895,000	2,024,000
392	Биет хөрөнгө	3,895,000	2,024,000
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,569,700	10,569,700
39206	Хуримтлагдсан элэгдэл	7,031,700	8,851,700
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	510,000	510,000
39208	Хуримтлагдсан элэгдэл	153,000	204,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,216,127,649	3,692,970,367
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,256,830,160	1,624,126,851
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,256,830,160	1,624,126,851
413	Өглөг	159,850,984	-
4136	Бусад өглөг	159,850,984	-
41361	Байгууллагад төлөх өглөг	159,850,984	-
414	Урьдчилж орсон орлого	9,096,979,176	1,624,126,851
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	9,096,979,176	1,624,126,851
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,915,827,156	2,068,843,516
51	Засгийн газрын хувь оролцоо	1,915,827,156	2,068,843,516
512	Хуримтлагдсан үр дүн	1,915,827,156	2,068,843,516
51210	Өмнөх үеийн үр дүн	1,977,026,303	1,912,352,156
51220	Тайлант үеийн үр дүн	(61,199,147)	156,491,360
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,172,657,316	3,692,970,367

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	8,881,958,351.00	8,710,595,935.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,881,958,351.00	8,710,595,935.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,881,958,351.00	8,710,595,935.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,504,415,755.00	8,710,595,935.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,951,487,420.00	392,944,402.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	182,663,820.00	344,799,208.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	1,370,264,515.00	7,972,852,325.00
120009	Бусад орлого	377,542,596.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,939,807,698.32	8,554,104,574.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,939,807,698.32	8,554,104,574.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,939,807,698.32	8,554,104,574.79
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,937,936,698.32	8,552,233,574.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,937,936,698.32	8,552,233,574.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,871,000.00	1,871,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,871,000.00	1,871,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(57,849,347.32)	156,491,360.21
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,349,800.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,349,800.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,349,800.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(61,199,147.32)	156,491,360.21

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			1,915,827,155.79	1,915,827,155.79
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,915,827,155.79	1,915,827,155.79
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,915,827,155.79	1,915,827,155.79
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,915,827,155.79	1,915,827,155.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-3,475,000.00	-3,475,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,912,352,155.79	1,912,352,155.79
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			156,491,360.21	156,491,360.21
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,068,843,516.00	2,068,843,516.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	16,191,269,282.00	1,427,603,726.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,108,389,129.00	1,298,177,421.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,108,389,129.00	1,298,177,421.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,503,187,813.00	1,298,177,421.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,320,523,993.0	892,944,402.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	182,663,820.0	405,233,019.0
120009	Бусад орлого	605,201,316.0	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	82,880,153.00	129,426,305.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	82,880,153.00	129,426,305.0
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	82,880,153.0	129,426,305.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	9,036,162,925.32	8,871,795,363.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,036,162,925.32	8,871,795,363.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,953,282,772.32	4,484,996,340.85
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,953,282,772.32	4,484,996,340.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,953,282,772.3	4,484,996,340.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,880,153.00	4,386,799,023.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	82,880,153.00	129,426,305.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	82,880,153.0	129,426,305.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	4,257,372,718.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,257,372,718.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,155,106,356.68	(7,444,191,637.85)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	7,155,106,356.68	(7,444,191,637.85)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,826,814,745.17	10,981,921,101.85
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,981,921,101.85	3,537,729,464.00

Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Эрдэнэт сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Эрдэнэт сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 06/123 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Эрдэнэт сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Засгийн газар болон Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зарим арга хэмжээг санхүүжүүлэх
- Аймгийн хөгжлийн ирээдүйтэй шууд холбогдсон оюуны хөрөнгө оруулалт хийх, шинжлэх ухааны ололт, шинэ технологи нэвтрүүлэх
- Үнийн эрсдэлээс хамгаалахад зориулж хөрөнгө төлөвлөх, зарцуулах
- Хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын арга хэмжээ, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох
- Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх, ашиглалтын болон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх
- Хотын усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, орон сууц, нийтийн аж ахуй, үерийн хамгаалалтыг зохион байгуулах
- Төвөөс хэрэгжүүлж байгаа орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх зайлшгүй шаардлагатай төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх
- Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг шинээр нэмэгдүүлэх

- Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр он дамжин хийгдэх ажлын олгогдоогүй үлдэгдэл болон хөрөнгө оруулалтын ажлын баталгааны 5 хувийг жилийн эцэст “Эрдэнэт сан”-д төвлөрүүлэн дараа онд ажлын гүйцэтгэлийг үндэслэн санхүүжүүлэх
- Сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банканд байршуулж хүүгийн орлогыг сангийн зорилго, үндсэн чиглэлийн дагуу соёл, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарт хөрөнгө оруулалт хийхэд төлөвлөж, зарцуулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдөр өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Эрдэнэт сан нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 8,710,595.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 87,105.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75%-иар 65,329.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Эрдэнэт сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,479,686.9 мянган төгрөгөөр буюу 33.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж орсон орлого, өр төлбөр, авлагын данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,981,921.1	3,537,729.5	(7,444,191.6)
Авлага	186,841.2	153,216.9	(33,624.3)
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	3,895.0	2,024.0	(1,871.0)
Нийт хөрөнгө	11,172,657.3	3,692,970.4	(7,479,686.9)
Өр төлбөр	159,850.9	-	(159,850.9)
Урьдчилж орсон орлого	9,096,979.2	1,624,126.9	(7,472,852.3)
Хуримтлагдсан үр дүн	1,915,827.2	2,068,843.5	153,016.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,172,657.3	3,692,970.4	(7,479,686.9)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,537,729.5 мянган төгрөг болж 7,444,191.6 мянган төгрөгөөр буурсан нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас орж ирсэн хамтын ажиллагааны хүрээнд дэх хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж гүйцэтгэлийн санхүүжилт олгосноос шалтгаалжээ.
- Авлагын дансны эцсийн үлдэгдэл 153,216.9 мянган төгрөг болж 33,624.3 мянган төгрөгөөр буурсан нь шахмал түлштэй холбоотой насжилт өндөртэй Элбос трейд ХХК-ийн 31,900.0 мянган төгрөгийн авлагаас тайлант онд 8,577.8 төгрөг төлөгдөж 23,322.2 мянган төгрөг үлдсэн. Мөн өмнөх онд өвөлжилтийн бэлтгэл ажил хангах хүрээнд 6,469.7 мянган төгрөгийн үүссэн авлага, Эрдэнэт сангаас ХХААГ-т олгосон зээлийн 18,576.7 мянган төгрөгийн авлага тус тус барагдсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,024.0 мянган төгрөг болж 1,871.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.
- Урьдчилж олсон орлого 1,624,126.9 мянган төгрөг бөгөөд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж буй ажлуудын үлдэгдэл санхүүжилт 1,598,728.4 мянган төгрөг, БШУЯ-ны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 23,398.4 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,068,843.5 мянган төгрөг болж 153,016.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 156,491.4 мянган төгрөг, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 3,475.0 мянган төгрөг бүртгэснээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит 2 дугаар хуралдааны 02/05 дугаар тогтоолоор Эрдэнэт сангийн 2021 оны орлогыг 15,069,864.7 мянга, санхүүжилтээр хийгдэх 35 төсөл арга хэмжээний зардлын төсвийг 15,069,864.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 16-ний өдрийн ээлжит бус 03 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолоор Эрдэнэт сангийн төсөвт өөрчлөлт оруулж урьд оны шилжих үлдэгдлийг 2,980,349.9 мянган төгрөгөөр бууруулж 9,567,124.4 мянган төгрөг болгон өөрчилсөн.

Өөрчлөлт оруулсан орлогын задаргааг үзэхэд: /мян.төгрөг/

№	Төрөл	Аймгийн ИТХ-ын 02/05	Аймгийн ИТХ-ын 08 тогтоол	Зөрүү
1	Орон нутгийн байрны түрээсийн орлого	125,160.7	325,598.0	(200,437.3)
2	Газрын дуудлага худалдаа, төсөл шалгаруулалтын эзэмшүүлэх үйл ажиллагааны орлого	346,144.7		346,144.7
3	Реклам, сурталчилгааны самбараас орох орлого	16,085.0	16,085.0	-
4	ГБХЗХГ-ын үйл ажиллагааны орлого	35,000.0	35,000.0	-
4	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-тай хамтын ажиллагааны хүрээнд орох орлого	2,000,000.0	2,000,000.0	-
5	Урьд оны шилжих үлдэгдэл	12,547,474.3	9,567,124.4	2,980,349.9
	Нийт орлого	15,069,864.7	11,943,807.4	3,126,057.3

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106 /ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага/ хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 11,943,807.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 376,683.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 9,567,124.4 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс /мөнгөн хөрөнгийн үлдэгдэл/, 2,000,000.0 мянган төгрөгийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтын ажиллагааны хүрээнд санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр эрдэнэт сангийн дансанд 1,427,603.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, аймгийн ИТХ-аар батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн зардалд 8,871,795.4 мянган төгрөгийг зарцуулж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 3,537,729.5 мянган болсон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрдэнэт санд нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн Эрдэнэт сангийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 1 талбарын мэдээллээс 1 талбарын мэдээллийг хугацаанд нь оруулсан байна. Эрдэнэт сан нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тусдаа цэсгүй бөгөөд Орхон аймаг цэсэд 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалтаа мэдээлдэг байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 5,280.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 193,393.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 14,819.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт-4

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	5,280.2	1	5,280.2	-		
Албан шаардлага	1	193,393.7	1	193,393.7	-	-	-
Зөвлөмж	2	14,819.0	2	14,819.0	-		-
Нийт дүн	4	213,492.9	4	213,492.9			-

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 153,216.9 мянган төгрөгийн 1 алдаа зөрчил илэрснээс 153,216.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

Залруулагдаагүй 1 алдааны зөрчлийн дүн 153,216.9 мянган төгрөгийг материаллаг бус гэж үзэж тогтоосон материаллаг байдлын түвшин 87,105.9 мянган төгрөгөөс материаллаг алдаа зөрчлийн дүн хэтрээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа: Санхүүгийн аудитаар хийгдсэн залруулга байхгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой

Илрүүлэлт:

Өмнөх онуудад үүссэн он дамжсан, насжилт ихтэй 186,841.2 мянган төгрөгийн авлагаас тайлант онд 33,624.3 мянган төгрөгийн авлага барагдаж 153,216.9 мянган төгрөгийн 8 төрлийн авлага бүртгэлтэй ба оны эцэст тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Насжилт өндөртэй авлагыг бүрэн барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрдэнэт сан	1	153,216.9							1	153,216.9